



**Ховд аймгийн Хэвлэл мэдээллийн  
тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр**

**Нэг. Хөтөлбөрийн үндэслэл**

Ховд аймагт хэвлэл мэдээллийн 4 телевиз, 2 сонины газар, 2 богино долгионы радио, 2 цахим мэдээллийн хэрэгсэл тус тус үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 30 орчим хэвлэл мэдээллийн ажилтан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлгийн 4.1.7.2-т “Хэвлэл мэдээллийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг дэмжиж чадавхжуулах, хөтөлбөрт хамруулах, төрөөс хамтарч ажиллахдаа тэгш зарчим баримтлах зэргээр тухайн салбарын санал, санаачилгыг хуулийн хүрээнд дэмжин ажиллаж, төрийн үйлчилгээг олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдүүлж салбарын ажиллагсдын ажиллах нөхцөл, баталгааг сайжруулна” гэж заасан байна.

Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.2.2 дахь заалтуудыг үндэслэн Орон нутагт хэвлэл мэдээллийн салбар тогтвортой хөгжих боломжийг бүрдүүлэх, хөгжлийг дэмжих, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор энэ хөтөлбөрийг боловсрууллаа.

**Хоёр: Хөтөлбөрийн зорилго**

Ховд аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг чадавхжуулах, хэвлэл мэдээллийн ажилтнууд, сурвалжлагч, сэтгүүлчдийн ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, мэргэжлийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, нийгмийн хариуцлагыг эрхэмлэж ажиллах бололцоог бүрдүүлэх, мэдлэг, чадварт суурилсан, тогтвортой хөгжлийн зарчмыг хэрэгжүүлэхэд уг хөтөлбөрийн зорилго оршино.

**Гурав: Зорилтууд**

3.1. Мэргэжлийн сэтгүүл зүйг хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд дэвшилтэт технологи, арга барил нэвтрүүлэх

3.2. Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

3.3. Салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх сургалтанд хамруулах

3.4. Сэтгүүл зүйн салбарын гадаад, дотоод харилцааг хөхүүлэн дэмжих

3.5. Олон нийтийг гэгээрүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн идэвхтэй үйл ажиллагааг дэмжих

### **Дөрөв: Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

#### **1 дүгээр зорилтын /3.1/ хүрээнд:**

4.1.1.Хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааны чанар чансаа, үр нөлөөг сайжруулах урамшууллын хөшүүрэг бий болгох

4.1.2.Мэргэжлийн үйл ажиллагааг үнэлэх, урамшууллыг зохицуулах үүрэг бүхий зохицуулах зөвлөл байгуулах

4.1.3.Хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлэх, хөдөлмөр, бүтээлийг үнэлэх, урамшуулах хэрэгжүүлэх

4.1.4.Хамтарсан уран бүтээл, томоохон контент гаргах

#### **2 дугаар зорилтын (3.2) хүрээнд:**

4.2.1.Хэвлэл мэдээллийн байгууллагуудад тогтвортой үйл ажиллагаа явуулах бололцоог бүрдүүлэх зорилгоор дэмжлэг олгох

4.2.2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарчмуудыг хэрэгжүүлж, төр, захиргааны зүгээс хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тэгш харилцах боломж бүрдүүлэх

4.2.3.Салбарын үйлдвэрчний эвлэлийг байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

#### **3 дугаар зорилтын (3.3) хүрээнд:**

4.3.1.Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажиллагсдын ажиллах нөхцөлийг сайжруулахад нь зориулагдах дэмжлэгийг тэдний мэргэжлийн үйл ажиллагааны үр дүн, хөтөлбөрийн хүрээнд өрнүүлж буй үйл ажиллагааны болзол шаардлагыг хангасан байдлыг нь үндэслэн жил бүр олгох

4.3.2.Сэтгүүлчдийг мэргэжлийн сургалтад хамруулах, үйл ажиллагаа, уран бүтээлийг нь үр нөлөөнд суурилсан, шударга зарчимд тулгуурлан урамшуулах

#### **4 дүгээр зорилтын (3.4) хүрээнд:**

4.4.1.Хөрш улс, бусад аймаг хотуудын сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагатай туршлага, мэдээлэл солилцох, харилцан туслах, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулах , хамтын бүтээл гаргах

4.4.2. Мэргэжил дээшлүүлэх сургалтанд үе шаттай хамруулах

#### **5 дугаар зорилтын (3.5) хүрээнд :**

4.5.1.Нийтийн эрх, эрх чөлөөг дээдлэх, хамгаалахад чиглэгдсэн, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэсэн, тэгш хүртээмжтэй, үнэн бодит мэдээллээр хангах, олон түмнийг соён гэгээрүүлэх сэтгүүл зүйн бүтээлүүд гаргах, хүргэх

4.6.2.Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааны үр дүн, нийгмийн хариуцлагыг эрхэмлэж, болзолт уралдаан, шилдэг нийтлэл, нэвтрүүлэг, сурвалжлаг шалгаруулах, танин мэдэхүйн боловсрол олгох хөтөлбөр, контент бий болгох, зарлаж дүгнэх

#### **Тав. Хөтөлбөрийн хүрэх үр дүн**

- 5.1. Үйл ажиллагаа, мэдээллийн хүртээмж цар хүрээ өргөжиж, аливаа санаачилга зүтгэлийг сурталчлах, танин мэдэхүйн, соён гэгээрүүлэх нэвтрүүлэг, суваг, контентын тоо нэмэгдсэн, үзэгч, захиалагч, дагагчдын тоо нэмэгдсэн байна
- 5.2. Технологийн дэвшлийг нэвтрүүлэн, шинэ контент бий болгох, мэргэжлийн сэтгүүл зүйг хөгжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.
- 5.3. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсад, сэтгүүлчдийн залгамж халааг сургах, чадавхжуулах боломж бүрдэнэ.
- 5.4. Сэтгүүл зүйн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэнэ.

#### **Зургаа: Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт:**

/Д	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин /оноор/	
		2018 он	2019 он	2020 он

1.	Мэргэжлийн чадварлаг сэтгүүл зүйн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх, дэвшилтэт технологи, арга барил нэвтрүүлэхэд үзүүлсэн дэмжлэг	20%	40%	60%
2.	Сэтгүүлчдийн мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр дүн	10%	20%	30%
3.	Тухайн байгууллагаас сэтгүүлчид, ажиллагсдынхаа ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлсэн дэмжлэг	0%	15%	30%
4.	Сэтгүүл зүйн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа	0%	15%	30%
5.	Аймаг орон нутгийн тулгамдаж буй асуудлыг хөндөж, эрэн сурвалжилсан, гарц, шийдэл олоход чиглэгдсэн бүтээлч, оновчтой санаа, гаргалгаа дэвшүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	5-аас илүүгүй	10-аас доошгүй	20-оос доошгүй
6.	Аймгийн Нутгийн өөрийн удирдлага болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, хууль тогтоомж, бодлого шийдвэрийг сурталчилсан, мэдээлсэн тоо	40-ээс илүүгүй	60-аас доошгүй	100-ас доошгүй
7.	Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээ, мэдээллүүдийн тоо	20-оос илүүгүй	40-ээс доошгүй	50-аас доошгүй
8.	Соён гэгээрүүлэх, танин мэдэхүй болон иргэдийн оролцоог төрийн бодлого, шийдвэр үйл ажиллагаанд нэмэгдүүлэхэд бодит дэмжлэг болсон нийтлэл, нэвтрүүлэг, мэдээллийн тооны өсөлт	10%	20%	30%
.	Аймаг, орон нутагт зохион байгуулсан томоохон үйл ажиллагааны мэдээллийн тоо, Хэвлэл мэдээллийн байгууллагуудаас нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх талаар санаачилсан үйл ажиллагаа	20-оос илүүгүй	35-аас доошгүй	50-аас доошгүй
10.	Олон үндэстэн, ястны өв соёлыг сурталчлах чиглэлд хийсэн ажлын тоо	5-аас илүүгүй	10-аас доошгүй	20-оос доошгүй

## **Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, зохион байгуулалт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Монголын сэтгүүлчдийн эвлэлийн харьяа Ховд аймгийн сэтгүүлчдийн салбар зөвлөл, олон нийт, байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн зохицуулах Зөвлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.

Зохицуулах зөвлөлийн дэргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан ажлын хэсэг байгуулж болно.

Ажлын хэсэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, зохион байгуулалтын хөтөлбөр, хяналт мониторингийн төлөвлөгөөг боловсруулан Зохицуулах зөвлөлөөр батлуулна.

Хөтөлбөрт жил бүр мониторинг хийж, хэрэгжилтийн явц болон үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч цаашдын зорилтыг тодорхойлно.

### **Найм. Зөвлөлийн эрх үүрэг**

#### **8.1.Зөвлөлийн бүрэн эрх:**

8.1.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

8.1.2.Хөтөлбөрийн санхүүжилтийг уг хөтөлбөрийн 9 дүгээр бүлэгт заасны дагуу зарцуулахтай холбоотой зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж шийдэх

8.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа шийдвэрийг Нутгийн удирдлага, Нутгийн захиргааны байгууллагаас хараат бусаар гаргаж, хэрэгжүүлэх

8.1.4.Хөтөлбөрт хамрагдсан салбарын байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, үр өгөөжийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, ажиллагсдын ёс зүй, хандлагыг сайжруулахад ажлаа чиглүүлж, зөвлөмж өгөх

#### **8.2.Зөвлөлийн үүрэг, хариуцлага:**

8.2.1.Хөтөлбөрийг үр өгөөжтэй хэрэгжүүлэх талаар хүч, бололцоогоо дайчлан, хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэхэд анхаарч ажиллах

8.2.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр хариуцан тайлагнах

8.2.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын болон жилийн эцсийн тайланд өгсөн дүгнэлт, мониторинг үнэлгээний үр дүнд гарсан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах

8.2.4.Зөвлөлийн бүрэн эрхийн 4 дэх хэсэгт тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх, үр дүнд хүргэх талаар санаачилгатай ажиллаж, хөтөлбөрийн заалт тус бүрийн тайлагналт, үр дүнд анхаарлаа хандуулж ажиллах

## **Ес. Хөтөлбөрийн санхүүжилт**

### **9.1. Хөтөлбөрийн санхүүжилт**

9.1.1. Хөтөлбөрт батлагдсан санхүүжилтийг Ховд аймаг дахь сэтгүүлчдийн байгууллагаас томилогдсон зохицуулах Зөвлөлд олгоно.

1.2. Зохицуулах зөвлөл нь санхүүжилтийг хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хуваарилан, зарцуулах эрх олгохдоо дараах зарчмыг чанд баримтална.

### **Хоёр. Санхүүжилт хуваарилан олгох зарчим**

2.1. Санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу зориулалт тус бүрээр нь авч үзэж, зайлшгүй урьдчилан санхүүжүүлэх шаардлагатай зардлыг зөвлөлийн шийдвэрийг үндэслэж, харин үр дүнг харгалзан олгох санхүүжилтийг тухайн үйл ажиллагааны үнэлгээ, үр дүнд үндэслэн олгоно

2.2. Хөтөлбөрийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагуудад олгох дэмжлэгийг санхүүжүүлэхдээ үйл ажиллагааны төрөл, статус, эзэмшлийн байдлаас хамаарахгүйгээр тухайн байгууллагын нийгэм олон нийтэд чиглэгдсэн үйл ажиллагааны үр дүнг үндэслэн олгоно.

2.3. Санхүүжилтийг байгууллагуудад хуваарилах зарчим нь:

- Тухайн улирал, жилд, тухайн байгууллагаас бэлтгэн олон нийтэд түгээж буй бүтээгдэхүүнүүдийн мэргэжлийн чанар
- Нийгэм, олон нийтэд үзүүлэх бодит үр нөлөө
- Шинэ технологи арга барил нэвтрүүлэх, ажиллагсдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийтлэлийн бодлого, төлөвлөгөө, хүний нөөцөө сургах чадавхжуулах талаар байгууллагын дотоодод хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээ, түүний үр дүнг үндэслэл болгоно

2.4. Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмжиж урамшуулахдаа дараах шалгууруудыг харгалзана. Үүнд:

- Сэтгүүлчдийн бүтээлүүдийн хувьд тулгамдаж буй асуудлуудыг хөндөж, гарц, шийдэл олоход чиглэгдсэн, оновчтой санаа оноо дэвшүүлсэн, оюун дүгнэлтэд хөтөлсөн байдал
- Олон нийтийг соён гэгээрүүлэх, танин мэдүүлэхэд чиглэгдсэн бүтээлийн чанар чансаа
- Эрэн сурвалжилсан сэтгүүл зүйн бүтээлийн чанар чансаа, мэргэжлийн шалгуур, бодит үр нөлөө

- Олон нийтэд болон дотоод, гадаадын ижил төрлийн мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдэд үнэлэгдсэн байдал, хамтарсан бүтээлийн чанар чансаа
- Иргэд олон нийтийн мэдэх эрхийг дэмжих, тэдэнд нэн шаардлагатай мэдээлэл, мэдлэг олгоход чиглэгдсэн, иргэд олон нийтийн хүсэлтээр бэлтгэгдсэн бүтээлийн тоо, чанар
- Хуулийн хүрээнд иргэд, олон нийтийн дуу хоолойг нийтэд хүргэсэн үйл ажиллагааны тоо, чанар

**Гурав: Үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зарчим**

- 3.1. Сэтгүүлч тус бүрийн ажлын үр дүнг урамшуулах асуудлыг байгууллага тус бүр дотооддоо зохицуулна.
- 3.2. Байгууллага болон сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ зохицуулах зөвлөлийн гишүүдийн ердийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 3.3. Зохицуулах зөвлөлийн гишүүдийн ажлын урамшуулал нь тухайн жилд батлагдсан санхүүжилтийн 3 хувиас хэтрэхгүй байна.

-----oOo-----